



ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР  
ГАМШИГ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ  
ХҮРЭЭЛЭН

Партизаны гудамж, Сүхбаатар дүүрэг,  
Улаанбаатар хот, 14250  
Утас: 26 12 53, Факс: (976-51) 26 28 46,  
Цахим шуудан: nidr@nema.gov.mn,  
Цахим хуудас: www.nidr.nema.gov.mn

2024.08.29 № 12/96

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

БОЛОВСРОЛЫН ЯАМНЫ ТӨРИЙН  
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Х.БАТЖАРГАЛ  
ТАНАА

Онцгой байдлын байгууллагын 20 жилийн ойн хүрээнд  
"Гамшгийн эрсдэлийг бууруулах шинжлэх ухаанч  
санаачилга-2" сэдэвт үндэсний уралдааныг 2024 оны 11  
дүгээр сарын 07-ны өдөр зохион байгуулахаар төлөвлөн  
ажиллаж байна.

Хавсралтад заасан удирдамжийн дагуу эрдэмтэн,  
судлаач алба хаагч Та бүхнийг бүтээлээ ирүүлэхийг хүсье.

Холбоо барих, өгүүлэл ирүүлэх хаяг:  
Утас:99039012, 80180990, 51-263543  
Цахим шуудан: nema.dri.mn@gmail.com

Хүндэтгэсэн,

ЗАХИРАЛ,  
ХУРАНДАА



Ж.АМГАЛАН

БАТЛАВ  
ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
ДАРГА, ХОШУУЧ ТЕНЕРАЛ  
..... ГАРИУНБУЯН  
2024 оны 08 дүгээр сарын 15 -ны өдөр

**“ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ШИНЖЛЭХ УХААНЧ САНААЧИЛГА-2”  
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БҮТЭЭЛИЙН ҮНДЭСНИЙ  
УРАЛДААНЫ УДИРДАМЖ**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

Гамшгийн эрсдэлийг бууруулах, гамшгаас хамгаалах үндэсний чадавхыг нэмэгдүүлэх, гамшгаас урьдчилан сэргийлэхэд иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, гамшгийн удирдлага түүний тогтолцоог бэхжүүлэх, сайжруулах асуудал чухлаар хөндөгдөж байна.

“Гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр 2015-2030 онд хэрэгжүүлэх Сендайн үйл ажиллагааны хүрээ” баримт бичигт “гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр судалгаа хийж, гамшгийг хохирол багатай даван туулах, хохирлын хэмжээг багасгахад чиглэсэн орчин үеийн дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлнэ” гэж тэмдэглэсэн.

Монгол Улсын тогтвортой хөгжлийн бодлого Алсын хараа 2050 баримт бичигт “Гамшгийн эрсдэлийг бууруулах сөрөг үр дагаврыг багасгах, гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний хөтөлбөрийг шинэчилж хэрэгжүүлнэ (2031-2040)” “Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, тэсвэрлэх чадавхыг бэхжүүлж, үүсэж болзошгүй эрсдэлийг бууруулна (2021-2030)” гэж тусгажээ.

Гамшгийн эрсдэлийг бууруулах, уур амьсгалын өөрчлөлт түүнд тулгарч байгаа эрсдэлт хүчин зүйлүүдийг тодорхойлоход шинжлэх ухааны үндэслэлтэй судалгаа, шинжилгээ хийх ажлыг эрчимжүүлэх, дэмжих, урамшуулах, хэрэглээнд нэвтрүүлэх замаар гамшгийн сөрөг үр дагаврыг багасгахад бодитой хувь нэмэр оруулан ажиллах нь холбогдох бүхий л талын идэвх оролцооноос шалтгаалдаг.

Иймд Онцгой байдлын ерөнхий газар, Гамшиг судлалын үндэсний хүрээлэн хамтран *Онцгой байдлын байгууллагын 20 жилийн ойн хүрээнд “Гамшгийн эрсдэлийг бууруулах шинжлэх ухаанч санаачилга- 2”* сэдвээр онол, практикийн ач холбогдол бүхий үндэсний уралдаан зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.

**Хоёр. Зорилго**

Гамшгийн эрсдэлийг бууруулах, гамшигтай тэмцэх чадавхыг сайжруулах чиглэлээр залуу судлаач, эрдэмтэн, мэргэжилтнүүдийн судалгаа, эрдэм шинжилгээний ажлыг эрчимжүүлэх, дэмжих, урамшуулах, нийтийн хүртээл болгох,

хэрэглээнд нэвтрүүлэх замаар гамшгийн аюулыг даван туулах, дасан зохицох, гамшгийн сөрөг үр дагаврыг багасгах, гамшгийн эрсдэлийг бууруулахад бодитой хувь нэмэр оруулахад оршино.

### **Гурав. Зохион байгуулагч**

Онцгой байдлын ерөнхий газар, Гамшиг судлалын үндэсний хүрээлэн хамтран зохион байгуулна. Ивээн тэтгэх, дэмжлэг үзүүлэх байгууллагыг хүлээн авах боломжтой.

#### **Дөрөв. Хүлээн авах эрдэм шинжилгээний бүтээлийн чиглэл**

- Гамшгийн эрсдэлийг бууруулах, бэлэн байдал, онол арга зүй, удирдлага, зохион байгуулалт, төлөвлөлт, хууль эрх зүйн орчин;
- Гамшигтай тэмцэх чадавхыг нэмэгдүүлэх, бэлтгэл, бэлэн байдлыг хангах;
- Гамшгаас хамгаалах, гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаан дахь салбар хоорондын хамтын ажиллагаа;
- Гамшгаас хамгаалах үндэсний чадавхыг нэмэгдүүлэх, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицож, гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд шинэ технологи, инновацыг бий болгох, нэвтрүүлэх боломж, туршлага;
- Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй гамшгийг даван туулах, дасан зохицох чадавхыг бэхжүүлэх;
- Гамшгийн эрсдэлийг бууруулахад олон нийтийн оролцоо;
- Гамшгаас хамгаалах харилцаа холбоо, хүн амын бэлэн байдал;
- Салбар дундын уялдаа холбоо, хамтын ажиллагаа, тулгамдсан асуудлууд, шийдлийн арга хэлбэр;
- Тусгай хэрэгцээт бүлэгт эрт зарлан мэдээллийг хүртээмжтэй хүргэх, цахим системд суурилсан сургалтын шинэ инновацыг нэвтрүүлэх;

#### **Тав. Хамрах хүрээ, зохион байгуулалт**

"Гамшгийн эрсдэлийг бууруулах шинжлэх ухаанч санаачилга-2" сэдэвт үндэсний уралдааныг 2 үе шаттай зохион байгуулна.

I шатанд – Удирдамжид заасан чиглэлийн дагуу ирүүлсэн эрдэм шинжилгээний өгүүлүүдийг тухайн чиглэлээр мэргэшсэн эрдэмтэн судлаачдаас бүрдсэн ажлын хэсэг шүүн хэлэлцэж шаардлага хангасан бүтээлийг дараагийн шатанд шалгаруулах.

II шатанд - Шалгарсан бүтээлүүдийн хүрээнд нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулж, шүүгчдийн бүрэлдэхүүнтэйгээр байр эзлүүлэх, урамшуулах, бүтээлүүдийг эмхэтгэн хэвлүүлж нийтийн хүртээл болгох;

Уралдааны I шатыг 2024 оны 10 дугаар сарын 24-ний өдөр, II шатыг 11 дүгээр сарын 07-ны өдөр тусгай хөтөлбөрийн дагуу зохион байгуулна.

Уралдаанд удирдамжид заасан чиглэлийн хүрээнд судалгаа, эрдэм шинжилгээний ажил хийдэг эрдэмтэн, судлаач, судлаачдын баг, их, дээд сургуулийн оюутнууд, тухайн чиглэлээр мэргэшсэн мэргэжилтнүүд оролцох боломжтой.

Уралдаанд оролцох бүтээлийг 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдрийг хүртэл хүлээн авна. Холбоо барих, өгүүлэл ирүүлэх хаяг: Утас: 99039012, 80180990, 51-263543. Цахим шуудан: [nema.dri.mn@gmail.com](mailto:nema.dri.mn@gmail.com)

### **Зургаа. Эрдэм шинжилгээний өгүүлэлд тавигдах шаардлага**

Уралдаанд оролцох эрдэм шинжилгээний өгүүлэл нь удирдамжийн 4-т заасан чиглэлийн хүрээнд бичигдсэн байх бөгөөд дор дурдсан шаардлагыг хангасан байна.

#### **1. Эрдэм шинжилгээний өгүүллийн бүтцэд тавигдах шаардлага**

- Өгүүлэл/илтгэлийн нэр
- Зохиогчдын овог, нэр; эрдмийн зэрэг, цол; байгууллага/албан тушаал
- Хураангуй
- Түлхүүр үг
- Оршил (судалгааны асуудал, үндэслэл, хэрэгцээ шаардлага)
- Судалгааны арга зүй, аргачлал
- Судалгааны үр дүн
- Хэлэлцүүлэг /бүтээгдэхүүний шийдэл/
- Дүгнэлт /санал, зөвлөмж/
- Номзүй

#### **2. Эрдэм шинжилгээний өгүүллийн хэлбэржүүлэлтэд тавигдах шаардлага**

Өгүүллийг А4 хэмжээтэй 8-15 хуудаст багтаан дараах форматаар бичиж ирүүлнэ.

- Хэрэглээний программ: Microsoft Word
- Үсгийн фонд: Arial
- Бичвэр доторх зураг: 300-400 dpi-аас багагүй нягтшилтайгаар зургийн \*.JPEG

өргөтгөлтэй

- Бичвэрийн өндөр: 12
- Мөр хоорондын зай: 1.15
- Бичвэрийн тохиргоо: Дээр-1.5см, доор-2см, зүүн-3см, баруун-1.5см
- Өгүүллийг цахимаар ирүүлэх ба зохиогчийн зураг, товч танилцуулгыг хавсаргана. /Биет бүтээлийг эх хувилбараар авч ирэх/

- Зохиогчийн эрдмийн зэрэг, цол, цэргийн цол, албан тушаал, илтгэлийн сэдэв, хураангуй, түлхүүр үгсийг англи, монгол хэл дээр бичсэн байна.

## **Долоо. Шагналын төрөл**

Шилдэг бүтээлийг дараах төрлөөр шалгаруулна. Үүнд: Эрдэм шинжилгээний өгүүлэл болон биет бүтээл. Төрөл тус бүрээр дараах байр эзлүүлнэ.

- ✚ 1-р байр;
- ✚ 2-р байр;
- ✚ 3-р байр;
- ✚ Тусгай байр;
- ✚ Нэрэмжит шагнал гэсэн төрлөөр тус тус шалгаруулна.

Гамшиг судлалын үндэсний хүрээлэнгийн Эрдмийн зөвлөлийн гишүүд удирдамжид /хүснэгтэд/ заасны дагуу шалгаруулалтын I шатыг шүүн хэлэлцэж авсан оноогоор эрэмбэлэн 70-аас дээш оноо авсан бүтээлийг II шатны шалгаруулалтад оруулна.

II шатны шалгаруулалтыг нээлттэй хэлэлцүүлж Гамшиг судлалын үндэсний хүрээлэн, Онцгой байдлын ерөнхий газартай хамтран баталсан шүүгчдийн баг шалгаруулна.

### **Найм. Бүтээлийг сонгон шалгаруулах ажлын хэсэгт тавигдах шаардлага**

- Сонгон шалгаруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
- Гамшгаас хамгаалах болон гамшгийн эрсдэлийн чиглэлээр дагнан 5-аас дээш жил ажилласан;
- Сургалт, судалгааны байгууллага болон бүхий л төрлийн техник технологи, инновацын чиглэлээр мэргэшсэн, одоо ажиллаж байгаа;
- Судлаач, шинжээчийн хариуцлага, ёс зүйн зөрчилгүй байх;
- Шүүмжлэгч, шинжээч нь гамшгаас хамгаалах болон холбогдох бусад шинжлэх ухааны салбарын чиглэлээр мэргэшсэн, мэргэжлийн зэрэг, цолтой байх гэх мэт.

Уралдааны II шатны шалгаруулалтыг шүүх ажлын хэсгийн гишүүдэд ажлын хөлс олгож болно.

### **Ес. Бүтээлийг шалгаруулах шалгуур үзүүлэлт**

Удирдамжид заасан шаардлагыг хангасан бүтээлийг зохиогчийн нэр хаяггүйгээр I шатны шалгаруулалтад оруулах ба ГСҮХ-ийн Эрдмийн зөвлөлийн гишүүд хавсралтад заасан шалгуураар 2024 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн дотор шалгаруулж, оролцогчдод мэдээлнэ.

I шатнаас шалгарсан бүтээлийг II шатны шалгаруулалтанд оруулна.

I шатнаас шалгарсан бүтээлийг зохиогчид урьдчилан мэдэгдэж зохиогч өөрийн биеэр II шатанд илтгэл хэлэлцүүлэн оролцох бэлтгэл ажлыг хангуулна.

II шатны шүүн хэлэлцэх хурал 2024 оны 11 дүгээр сарын 07-нд зохион байгуулагдах ба ажлын хэсэг дараах шаардлагыг харгалзан үнэлнэ. /Хүснэгт 1-т харуулав./

Хүснэгт.1 Уралдаанд оролцох бүтээлийг шалгаруулах шалгуур үзүүлэлт, оноо

д/д	Шалгуур	Авбал зохих оноо
1	<p>Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд нэн чухал шаардлагатай дараах чиглэлээр бичигдсэн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Гамшгийн эрсдэлийг бууруулах, бэлэн байдал, онол арга зүй, удирдлага, зохион байгуулалт, төлөвлөлт, хууль эрх зүйн орчин;</li> <li>- Гамшигтай тэмцэх чадавхыг нэмэгдүүлэх, бэлтгэл, бэлэн байдлыг хангах;</li> <li>- Гамшгаас хамгаалах, гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаан дахь салбар хоорондын хамтын ажиллагаа;</li> <li>- Гамшгаас хамгаалах үндэсний чадавхыг нэмэгдүүлэх, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицож, гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд шинэ технологи, инновацыг бий болгох, нэвтрүүлэх боломж, туршлага;</li> <li>- Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй гамшгийг даван туулах, дасан зохицох чадавхыг бэхжүүлэх;</li> <li>- Гамшгийн эрсдэлийг бууруулахад олон нийтийн оролцоо;</li> <li>- Гамшгаас хамгаалах харилцаа холбоо, хүн амын бэлэн байдал;</li> <li>- Салбар дундын уялдаа холбоо, хамтын ажиллагаа, тулгамдсан асуудлууд, шийдлийн арга хэлбэр;</li> <li>- Тусгай хэрэгцээт бүлэгт эрт зарлан мэдээллийг хүртээмжтэй хүргэх, цахим системд суурилсан сургалтын шинэ инновацыг нэвтрүүлэх;</li> </ul>	40
2	Бүтээлийн агуулга нь техник, технологийн инновац, арга аргачлалын талаар шинэ санал, санаачлага гаргасан байдал	30
3	<p>Бүтээлийг боловсруулахдаа уралдааны удирдамжид заасан дараах шаардлагыг хангасан эсэх. Үүнд:</p> <p>3. Эрдэм шинжилгээний өгүүллийн бүтцэд тавигдах шаардлага</p> <ul style="list-style-type: none"> <li>- Өгүүлэл /илтгэлийн нэр /</li> <li>- Зохиогчдын овог, нэр; эрдмийн зэрэг, цол; байгууллага/албан тушаал</li> <li>- Хураангуй</li> <li>- Түлхүүр үг</li> <li>- Оршил (судалгааны асуудал, үндэслэл, хэрэгцээ шаардлага)</li> <li>- Судалгааны арга зүй, аргачлал</li> <li>- Судалгааны үр дүн</li> <li>- Хэлэлцүүлэг</li> <li>- Дүгнэлт /санал, зөвлөмж/</li> <li>- Номзүй</li> </ul>	30

	<p>4. Эрдэм шинжилгээний өгүүллийн хэлбэржүүлэлтэд тавигдах шаардлага:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Өгүүллийг А4 хэмжээтэй 15-20 хуудаст багтаан дараах форматаар бичиж ирүүлнэ.</li> <li>- Хэрэглээний программ: Microsoft Word</li> <li>- Үсгийн фонд: Arial</li> <li>- Бичвэр доторх зураг: 300-400 dpi-аас багагүй нягтшилтайгаар зургийн *.JPEG өргөтгөлтэй</li> <li>- Бичвэрийн өндөр: 12</li> <li>- Мөр хоорондын зай: 1.15</li> <li>- Бичвэрийн тохиргоо: Дээр-1.5см, доор-2см, зүүн-3см, баруун-1.5см</li> <li>- Өгүүллийг цахимаар ирүүлэх ба зохиогчийн зураг, товч танилцуулгыг хавсаргана.</li> <li>- Зохиогчийн эрдмийн зэрэг, цол, цэргийн цол, албан тушаал, илтгэлийн сэдэв, хураангуй, түлхүүр үгсийг англи, монгол хэл дээр бичсэн байна.</li> </ul>	
	Нийт	100

--oOo--